

БОЛОВСРОЛЫН МӨН ЧАНАР, ТҮҮНИЙ БЭЛГЭДЭЛ

Н.БЭГЭ

Нэг. Хураангуй

Түүхэн хөгжлийнхөө явцад олж авсан тархины их багтаамж, хөгжиж дэвших их боломжоороо л бусад амьтны үр зулзагаас ялгарахаас биш, хүний хүүхэд эхээс төрөхдөө хэлгүй, нэргүй, нэн өрөвдөлтэй улаан нялзрай амьтан байдаг. Түүнийг хүний нийгмийн орчинд арчилж бойжуулан, өсгөж, хөгжүүлэхгүй бол адгууснаас ялгаагүй амьтан болж хувирдаг. Хүн гэдэг нэртэй биологийн энэ амьтныг нийгмийн зохион байгуулалтаар амьдардаг, ухаалаг, бүтээлч, хүн гэдэг нийгмийн амьтан болгон төлөвшүүлж, хөгжүүлэх үүргийг гагцхүү боловсрол л гүйцэтгэнэ.

Боловсрол бидний амьдралын орчин болж, хүний өдөр тутмын үйл ажиллагааны салшгүй бүрэлдэхүүн хэсэг болж байгаа өнөө үед боловсролын дотоод мөн чанарыг тод илтгэн харуулж, ном, сэтгүүлд боловсрол гэдэг ухагдахууныг тодорхой дүрс тэмдгээр бэлгэдэн төлөөлүүлж байх нь боловсролын талаарх хүмүүсийн ойлголтыг гүнзгийрүүлэх, түүнийг танин мэдэхэд тус болох ач холбогдолтой. Уг асуудлаар уншигч, судлаачидтай санал солилцох зорилгоор өөрсдийн саналыг тусгасан энэхүү өгүүллийг та бүхэнд танилцуулж байна.

Хоёр. Боловсрол хэмээх ухагдахуун, түүний мөн чанар

Боловсрол нь бие хүний хөгжил, түүний амьдрал, үйл ажиллагаанд болон нийгмийн хөгжилд шийдвэрлэх үүрэгтэй хүчин зүйл болохыг хүн төрөлхтөн одоо нэгэн утгаар бүрэн хүлээн зөвшөөрдөг боллоо. Боловсрол нь нэг талаасаа өнөөдрийн хөгжлийн өндөрт хүрсэн ухаант хүний тодорхой зорилго чиглэлтэй, сайн зохион байгуулалт бүхий нийгмийн үйл ажиллагаа юм. Нөгөө талаас хүн төрөлхтөн боловсрол хэмээх нийгмийн энэ зохион байгуулалттай үйл ажиллагаанд хөгжлийнхөө маш эрт дээр үеэс орсон ба амьдралыг тасралтгүй үргэлжлүүлэх, үр удмаа үлдээх, үүний тулд хамтын аюулгүй байдлаа хангах төрөлх зөн нь түүнийг энэ үйл ажиллагаанд анх түлхсэн байх гэж таамаглаж болно.

Боловсрол анх үүссэн он цагийг яг нарийн тодорхойлох боломжгүй юм. Харин боловсрол нь нийгмийн хэрэгцээгээр төлөвшдөг үзэгдэл учир анх хүний нийгэм төлөвшиж бүрдэх нөхцөл нь боловсрол байсан ба цаашид нийгмийн хөгжлийн түвшин бүр нь өөртөө тохирсон, өөрийгөө авч явж хөгжүүлэх боловсролын тогтолцоотой болсон гэж үзэж болно. Газар дэлхий дээр хүн үүссэн он цагийг хөөн бодоход дэлхийн чийглэг, халуун дулаан

уур амьсгал аажмаар сэрүүсэж, их мөстлөгийн эхлэл ойртож байсан үетэй давхцдаг.

Ийнхүү төсөөлөн бодоход эрт галавын үеийн боловсрол нь өөрөө нийгмийн зориулалтаараа хүний хөгжлийн бүдүүлэг эрт тэр цагт байгалийн хатуу ширүүн уур амьсгал, өндөр уул, өргөн гол, цас мөсөн дунд, зэрлэг араатан, өөр овогтой тулалдан тэмцэж, үр удмаа үлдээн амьдрах тэсвэр хатуужил бүхий эртний үеийн эрэлхэг дайчин хүн төлөвшүүлэхэд голдуу чиглэж байсан бол уу гэх бодол төрдөг. Харин өнөөдөр бидний энэ үед бол эв эсийг эрхэмлэдэг, эх дэлхийнхээ хэмжээгээр сэтгэж, өөрийнхөө орны онцлог тааруулан ажиллаж, амьдарч чадах ухаант хүнийг төлөвшүүлж, түүнийг байнга тасралтгүй хөгжүүлэх нь түүний эрхэм зорилго болж байна. Өөрөөр хэлбэл, боловсрол нь үүсэл, төлөвшлийнхөө эхний шинжээр ч тэр, хөгжлийнхөө явцад олсон мөн чанараараа ч тэр байгалийн болон нийгмийн үндэстэй үйл ажиллагаа болж төлөвшсөн юм. Харин чоно бэлтрэгээ амьтан барихад сургаж байгаа, шувуу дэгдээхийгээ нисэж сургадаг зэрэг нь өнгөц харахад маш нарийн зохион байгуулалттай, тодорхой зорилго бүхий сургалт мэт харагдавч хүн төрөлхтний нялх балчир цагт бидний эртний өвөг дээдэс үр хүүхдээ сурган амьдралд бэлтгэж байсан тэр л амьтны зөн билгийн төвшинд гүйцэтгэгдэж буй маш энгийн ухамсарлагдаагүй үйл ажиллагаа юм.

Хүний нийгэм хэвийн байдлаар хөгжин дэвшихэд боловсрол хэмээх нийгмийн энэхүү институт онцгой чухал үүрэгтэй явж ирж. Цаашид ч ийм байна. Өнөөдрийн бидний үеийн хүний соёлын хөгжлийн хүрсэн түвшнийг дэмжиж, цаашид хөгжүүлэн боловсронгуй болгох үйл явц нь өнгөрсөн үеийнхний бий болгосон олон мянган жилийн соёлын өвийг эзэмшилгүйгээр хэрэгжүүлэх боломжгүй байдаг.

Өмнөх үеийнхний хөдөлмөрөөр буй болгосон материаллаг болон оюуны үнэт зүйлс, мэдлэгийн хуримтлал, хөдөлмөрийн дадлага туршлага, нийгмийн харилцааны дэвшилтэт уламжлал, хандлагыг дараа дараагийн үеийнхэнд уламжлуулан дамжуулж эзэмшүүлэх нь боловсролын нийгмийн үндсэн функц юм. Энэ зорилго нь хувь хүнийг нийгэмшүүлэх явцад шийдэгддэг бөгөөд уг үйл явцын гол зорилго нь хүнийг амьдрах ухаан, соёлын өв, ёс суртахууны хэм хэмжээнд суралцуулж, түүнийг нийгмийн бүрэн төгс гишүүн болгон төлөвшүүлэхэд оршино. Иймээс шинэ хүнийг нийгмийн гишүүн болгоно гэдэг нь цаанаа төлөвшиж тогтсон нийгэм, хамт олон өөрийн хамтын аюулгүй байдлаа хадгалахад чиглэж байгаа бөгөөд шинэ хүнийг нийгэм аюулгүй, өмнөх үеийнхний тогтоосон амьдралын хэм хэмжээ, ёс заншлыг бүрнээ даган биелүүлдэг дуулгавартай хүн, нийгмийн иргэн болгон төлөвшүүлэх философид үндэслэгдэнэ.

Боловсролыг олон талтай, өргөн хүрээтэй, нарийн нийлмэл бүтэцтэй үйл явц бүхий, нийгмийн эдийн засаг, улс төр, материаллаг хангамжийн түвшнийг тодорхойлдог, харьцангуй биеэ даасан тогтолцоо хэмээн үзэж болох боловч түүний хөгжлийн чиг баримжаа, хэрэгцээ, агуулга, түвшин нь ихэнх тохиолдолд түүний гадаад орчноос шууд хамааралтай байдаг. Боловсролын гадаад орчныг байгалийн ба нийгмийн гадаад орчин хэмээн ангилан үзэж болох ба байгалийн орчинд нутаг дэвсгэр, байршлын, байгаль цаг уурын, харин нийгмийн гадаад орчинд шашин, соёлын, нийгэм-улс төрийн, шинжлэх ухааны, эдийн засаг-эрхзүйн зэрэг олон дэд орчныг багтаан авч үзэж болно.

Гурав. Боловсролын талаарх өнөөгийн ойлголт

Боловсрол гэдэг ухагдахууныг эрдэмтэд янз бүрийн цаг үед янз бүрээр тодорхойлж ирсэн байдаг. Түүнийг өнөөгийн философи, түүхийн шинжлэх ухаан, эдийн засаг, эрх зүй, менежментийн болон бусад шинжлэх ухаануудын нүдээр харахад боловсрол нь хүний нийгмийг төлөвшүүлэн, түүний туршлагыг дараа дараагийн

нийгэмд уламжлуулж, мөн шинэчилж авч явдаг түүний хөгжлийн тэнхлэг, араг яс гэдэг нь тодорхой харагддаг. Түүний энэ мөн чанарыг олон шинжлэх ухааны уулзвар дээр судалдаг, өнгөрсөн зууны 60-аад онд бүрэн төлөвшиж үүссэн шинжлэх ухааны бие даасан том чиглэлийг боловсрол судлал гэнэ.

Боловсролыг нийгмийн хөгжилд оруулж буй хувь нэмрийн талаас нь социологийн шинжлэх ухааны нүдээр харвал, боловсрол гэдэг ойлголтод хүний өсөж өндийх, бойжиж төлөвших социаль орчин, ахуйн харилцаа болон нийгмийн дэвшил, өөрчлөлтөд дасан зохицох чиглэлээр хүмүүсийг үзэл баримтлалын тогтолцоотой болгох асуудлыг хамааруулж үзнэ.

Философи талаасаа боловсрол нь хүнийг өнөөгийн ертөнцөд нийгэм, боловсролын ямар чиг хандлагатайгаар хүмүүнжүүлэн төлөвшүүлэх, түүнд нийгмийн үнэт зүйлсийн ямар хэмжүүрийг хэрхэн суулгаж өгөх вэ? гэдэг үзэл баримтлал юм. Амьдралын аливаа асуудалд хандахдаа хэний эрх ашгийг түрүүнд тавих вэ? гэдгээсээ хамаарч хүмүүний төлөвшил, боловсролын философийг дотор нь эрдэмтэд олон ангилж үздэг.

Миний бодоход амьдрал, үйл ажиллагааны явцад хүнд төлөвшсөн уг төлөвшлийг аливаа асуудалд хандахдаа олны ашиг тусыг эрхэмлэх ёс суртахуун давамгайлсан (моральность) хандлагатай, өөрийн эрх ашгийг бүхнээс эрхэмлэх (рациональность) хандлагатай гэж хоёр хувааж үзэж болмоор санагддаг.

Боловсролыг түүхийн талаас нь хүн үүсэж бий болсон цагаас хойших боловсролын талаарх хүн төрөлхтний сэтгэлгээний хөгжлийн болон боловсролын үйл ажиллагааны үүсэл, хөгжлийн үе шаттай холбож авч үздэг. Иймээс монголын боловсролын түүх, дундад зууны боловсролын түүх гэх мэтээр авч үзнэ.

Сурган хүмүүжүүлэх ухааны талаас боловсрол гэдэг ухагдахууныг хүнийг амьдрал, хөдөлмөрт бэлтгэх зайлшгүй нөхцөл болсон байгаль, нийгэм, хүмүүнлэгийн тухай цэгцтэй мэдлэг, чадвар, дадал эзэмших үйл явц, үр дүнгийн нэгдлээр тодорхойлж авч үзнэ. Иймээс хүн сурах чиглэлийг эрхэм болговоос хандах зүг өөрөө тогтоно хэмээн их хүмүүс сургасан байдаг.

Эдийн засгийн талаас боловсролыг түүнд зарцуулсан хөрөнгө, хөдөлмөр, нөөц, санхүүгийн үр ашиг болон түүний нийгмийн үр дүнгийн талаас нь авч үзнэ. Судлаачдын үзэж байгаагаар эр зүйн шинжлэх ухааны үүднээс боловсрол нь нийгмийн бүтцийг байнга сэлбэн сайжруулах, түүний хөгжлийн эмх журмын түвшнийг

шаардлагатай хэмжээнд барих хэрэгсэл төдийгүй, төлөвшиж тогтсон нийгэм, хамт олны аюулгүй байдлын хэрэгцээг хангах үүднээс бий болсон, нийгмийн хөгжлийн тогтвортой байдлыг хангагч институци юм.

Боловсролыг эрдэмтэд удирдлагын шинжлэх ухааны үүднээс авч үзэхдээ боловсрол нь харилцан хамаарал, салшгүй шүтэлцээ бүхий орц явц-гарцын тогтолцоотой олон компонентуудыг багтаасан задгай супер систем бөгөөд нийгмийн их тогтолцооны нэг хэсэг, түүний хөгжлийн түвшин чадавхаас хамаарч хөгжих боловч эргээд нийгмийн хөгжлөө хөтлөгч шинжтэй, түүний тэргүүлэгч салбар байна гэж үздэг.

Эцэст нь боловсрол бол амьдралын хэв маягийг дэлгэрүүлэх, хүний авьяасыг хөгжүүлэх, хүн амын доторх бүлэг, хэсгийн нийгмийн ялгааг багасгах, нийгмийн шударга ёсыг хангах, шинжлэх ухаан техникийн хөгжил, эдийн засгийг тэтгэх, нийгмийн үйлдвэрлэх хүчнийг сурган бэлтгэж, нийгэмд оюуны болон эдийн засгийн хөрөнгө оруулалт хийх чухал үүрэг бүхий нийгмийн институци мөн.

Масст чиглэсэн боловсролын тухай орчин үеийн ойлголт гэвэл энэ нь хүнийг төрөхөөс аваад бурхан болох хүртэл хүрээлэн байдаг нийгмийн том орчныг бүхэлд нь боловсролын орчин гэж үзэх тухай асуудал болов. Энэ онолоор хүн насан турш сурдаг ажээ. Боловсрол өөрөө нээлттэй их систем учир түүний үр дүн, үргэлжлэл нь хүнийг насан туршид нь буюу нийгмийн их орчинд ч цуг дагаж явдаг. Тэгэхээр түүний чанар, үр дүнг хүний сурсан эрдэм нийгмийн их орчинд хэрхэн үйлчилж байгаагаар хэмжих хэрэгтэй юм [3.163].

Боловсролын үр дүнд хүн өөрөө хэрхэн хөгжив, байгаль, нийгмийн орчинд түүнийгээ хэрхэн хэрэглэж, хөгжүүлж, баяжуулж явна гэдгээр одоо нийгмийн хөгжлийн түвшнийг хэмжих боллоо. Иймээс сүүлийн жилүүдэд тухайн орны үндэсний үйлдвэрлэлийн өсөлтөд боловсролтой хүмүүс ямар хувь нэмэр оруулав, энэ ард түмний дотор нийгмийн гэмт хэрэг хэрхэн өсөв, хүн ардынх нь дундаж наслалт нь хэд байна, хүн ам нь өсөлтөө хэрхэн жолоодож байна, ажилгүй, амьдралгүй хүн хэд байна. Нэг хүн биш, бүхэл нийгмээрээ хэрхэн гэгээрээ вэ, хэр зэрэг боловсорсон нийгэм бэ гэдэг дээр илүү их анхаарал тавих боллоо.

Монголчуудын хувьд боловсролын уламжлал, түүний философи сэтгэлгээний хөгжил нь бидний амьдралын орчин, ард түмний маань амьдрах хэв маягтай маш нарийн холбоотойгоор хөгжиж ирсэн байдаг. Азийн төв хэсгийн өндөрлөг, далай тэнгисээс алслагдсан, байгалийн эрс тэс уур

амьсгалтай энүүхэн хэсэг, орос ч биш, хятад ч биш, өөр хэн ч биш, зөвхөн монголчууд л монгол маягаар амьдарч ирсэн нь тохиолдол бус юм. Жилийн 12 сарын найм нь хүйтэн сэрүүний улиралд хамрагддаг, газар тариаланд үндэслэгдсэн суурин соёл иргэншил тогтвортой хөгжих боломжоор хомс, төв азийн их цөлийн хойт хэсэг, дэлхийн бөмбөрцгийн хойт хэсгийн их цэвдгийн урд захын уулзвар дээр ихээхэн өндөрлөгт оршдог монгол нутагт цагийн сайхан, өвсний соргог, усны тунгалгийг бараадан, байгалийн бэрхшээлээс зугтан тэмцдэг нүүдэлчин монголчуудаас өөр улс, үндэстэн энд удаанаар оршин тогтнож чадаагүйг эдүгээ бидний өнгөрсөн хоёр мянган жилийн түүх бэлхнээ гэрчилнэ.

Тэгэхлээр бидний монголчуудын боловсрол нь энэ л байгаль, цаг уур, газар нутагтаа, жилийн 4 улиралд бууц сэлгэн нүүдэллэх нүүдэлчин амьдралдаа зохицсон, түүнийг цаашид үргэлжлүүлэн өвлүүлж, энэ газар нутагтаа амьдрах чадвар бүхий монгол хүнийг төлөвшүүлэн хөгжүүлэхэд чиглэж ирсэн бөгөөд өнөөдрийн бид энэ ард түмний олон мянган жилийн зорилго чиглэлтэй боловсролын үйл ажиллагааны үр дүн, бүтээгдэхүүн нь юм. Харин сүүлийн гурван зуун жилд суурин амьдралын явцад бий болсон өөр соёл иргэншлийн нөлөөгөөр дээр дурдсан монголчуудын үр удам, түүний тодорхой хэсэг нь амьдралын хэв маяг, эрхэмлэх үнэт зүйлсийн тогтолцоо, ёс заншил, ертөнцийг үзэх үзэл бодлоороо өвөг дээдсээсээ эрс ялгарах шинжийг олсон байна. Энэ нь эхэн үедээ өнгөрсөн зуунуудад эхлээд бидний авч хэрэглэсэн энэтхэг, түвд, хятад зүгийн, дараа нь европын герман, оросын боловсролын үйл ажиллагааны үр дүн байсан ба явцын дунд бидний төлөвшилд эртний ромын, япон-германы ба америкийн чөлөөт боловсролын нөлөө ч туссан гэж үзэж болно.

Дөрөв. Боловсролын мөн чанарыг бэлгэдлээр илэрхийлэх нь

Боловсрол, сургалтын мөн чанарыг энгийн, товч, тодорхой байдлаар илэрхийлэх, түүнийг бэлгэ тэмдгээр зурж дүрслэх оролдлого газар газарт өөр, өөр цаг үед гарсаар иржээ. Хүн маш эрт дээр үеэс үр хүүхдээ сурган хүмүүнжүүлэх цэгцтэй үйл ажиллагааг бий болгосон нь эртний хүмүүсийн амьдралд холбогдох хадны сүг зураг хадгалагдаж үлдсэн байхыг эртний судлалын эрдэмтэд олноор олж тогтоосон байна 5.30/. Өнгөрсөн зуунд, олон оронд ерөнхий боловсролыг номоор, мэргэжлийн тусгай боловсрол бүрийн онцлогийг тусган араа шүд,

онгоц, танк, тариа будаагаар ч төлөөлүүлэн ойлгодог, түүнийг дүрсэлж тэмдэглэдэг байсан байна. Дундад зуунаас эхтэй их сургуулийн бэлгэ тэмдэг нь голдуу эртний рыцарийн бамбай хэлбэртэй байдаг бол зэрэг хамгаалах түвшний боловсролыг библийг бэлгэдсэн номын хэлбэртэй малгайгаар төлөөлүүлэх хандлага нэлээд түгээмэл юм.

Боловсролын асуудал эрхлэх олон улсын болон бүс нутгийн байгууллагуудын эмблемийг ч олон янзаар хийдэг. НҮБ-ын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (юнеско)-ын эмблем нь үүний нэлээд сонгодог жишээний нэг мөн. Юнеско-г боловсрол, шинжлэх ухаан, соёлыг хөгжүүлэх дэлхийн гол байгууллага гэдэг утгаар нь эртний грек, ромын сонгодог стилийг ашиглан эрдэм, соёлын ариун сүмийн дүрсээр төлөөлүүлсэн байдаг. Ази, номхон далайн боловсролын шинэчлэл, хөгжлийн төвийн эмблем гэхэд дэлхийн бөмбөрцгийг ЮНЕСКО-ийн Ази, Номхон далайн боловсролын шинэчлэл, хөгжлийн төв гэсэн үгээр хүрээлүүлж, түүний голд ази, номхон далайн сав газрын зургийг дамнуулан ACEID гэсэн англи үгийг товчлон томоор бичсэн байх жишээтэй

Тав. Бидний санал

Боловсрол нь нийгмийг бүрэлдүүлж, түүнийг хөгжүүлж авч явдаг хүний нийгмийн «араг яс»-ны үүрэг гүйцэтгэдэг нь тодорхой боловч түүнийг аль өнцгөөс харснаасаа хамаарч, олон янзаар илэрхийлж болох нь боловсролын талаарх шинжлэх ухааны салбар ухагдахуунуудаас харагдана. Эдгээрийг харж явахдаа боловсролын өөрийнх нь дотоод мөн чанарыг бүрэн төгс илэрхийлж чадах, хялбар зохиомжтой, утга төгөлдөр бэлгэ тэмдэг бодож олох гэсэн хүслийг би олон жил санаандаа тээж явлаа.

Ийнхүү удаан бодсоны эцэст, боловсролын бэлгэдлүүдийн уламжлал дээр суурилан, тэдгээрт шинэчлэлийн өнгө аяс оруулах замаар бидний үеийнхний ойлголтод тулгуурлан боловсролын оэлгэ тэмдгийн нэг хувилбарыг олон түмэндээ санал болгож байгаа минь энэ. Эрдэмтдийн үзэж байгаагаар бэлгэ тэмдэг гэдэг нь «аль нэгэн утга санаа, биеийн болон ёс суртахууны үнэлэмжийг төлөөлсөн болзмол шинжтэй, нүднээ үзэгдэх дүрс» [4,5] юм.

Ийнхүү боловсролыг тодорхой бэлгэ тэмдгээр төлөөлүүлэн илэрхийлэхдээ түүний үйл явцын гурван үе шатыг дахин байх уун бүрэн утгаар нь боловсролыг эзэмшдэг гэсэн онолыг иш үндэс олгох нь зүйтэй гэж үзэв. Дээрхийн гэгээн XIV далай лам Данзанжамц энэ талаар хэлэхдээ

хүүхдийг ном сурахад бүрэн чадвартай болгох урван үе шат байдаг. Үүнд: бодитой хандах буюу нээлттэй сэтгэл, сэхээрэх буюу буддын номлолын утгыг ухаарч ойлгох, сонирхол буюу урам зоригтойгоор сурах эдгээр гурван чанар болой» [2.112] анхаарч үзэв. Мөн боловсролын доод шатнаас дараа дараагийн шатыг дамжин дээш дэвшин суралцах хүний тоо дэлхийн хэмжээгээр ойролцоогоор 10:3:1 гэсэн харьцаатай байгааг ч бас бодолцов. Иймээс ертөнц, амьдралын мөн чанарыг гурвын холбоост зүй тогтлоор илэрхийлдэг монгол сэтгэлгээний уламжлалыг баримтлан, нэг ерөнхий суурин дээр бие биеийг багтаан, цаашид алсан холдох, гурван үе бүхий адил талт гурвалжингаар боловсролыг төлөөлүүлэн дүрслэхээр шийдвэрлэв. Монголчуудын ертөнцийг үзэх үзэлд дулдуйдан, гурвалжин, түүний өнцөг, дээш харсан үзүүр нь өнгөрснөөс өнөө, цаашлаад ирээдүйд хязгааргүй тэмүүлэх хүний хүсэл, эрмэлзлийг төлөөлөн харуулдаг тул боловсрол нь өнгөрснийг ирээдүйд үргэлжлүүлдэг нийгмийн институци гэдэг утгаар нь бид түүнийг төлөөлүүлэх үндсэн бүтэц болгож, адил талт гурвалжинг эмблемийн суурь дүрс болгон сонгож авсан юм. Энэ нь сайн харвал бүхэлдээ номыг булан талаас нь өнцөгдүүлэн харахад гардаг хуудасны дүрс юм.

Боловсролын тухай бидний санал болгож байгаа энэ бэлгэ тэмдгийн зохиомжийг харсан хүн бүр өөрийн оюун ухаан, амьдралын туршлага, боловсролын мөн чанарын талаарх ойлголт, сэтгэлгээнийхээ цар хүрээгээр өөр өөрийн гайхамшигтай санааг гаргаж, түүгээрээ нэмэн тайлбарлаж болохыг үгүйсгэхгүй юм. Гэвч тэдгээр шинэ санаа бүхэн нь амьдрал гэгч өнгөрснөөс ирээдүйд тэмүүлэх түг түмэн жилийн хөгжлийн тасралтгүй урсгал, түүнийг тээгч хүмүүний олон мянган үеийнхний олж хуримтлуулсан их мэдлэг, туршлагын хуримтлал, түүнийг дараа дараагийн үеийнхэн нь хөгжүүлэн шинэчилж авч яваа, өнгөрсөн, одоо, ирээдүйд хамаарах үйл явц гэдэг дээр уулзаж нэгдэх бол уу гэж би бодож байна.

Энэ ертөнц, түүн дээрх амьдрал өөрөө хөгжил, хөдөлгөөн гэдэг утгаараа эхлэл, өрнөл, төгсгөл хэмээх гурван мөчлөгтэй тул түүнийг таньж мэдсэн монголын ард түмэн амьд мах бодийн үндсэн бүрдлийг хий, шар, бадган гэж ангилдаг, хүмүүний ертөнцийг аав, ээж, үр хүүхдийнх гэж гурван биед хувааж үздэг, оюун санааны ертөнцийн үндсийг бурхан, лам, ном гурав гэж ангилдаг болсон болов уу. Хувь хvн өөрөө өөртөө ертөнцийн төв байдгаас цаг хугацааны хувьд өнгөрсөн, одоо, ирээдүйн, орон зайн хувьд өөрөө болон түүнээс баруун, зүүн тийш, түүний оршин

буй цэг болон түүнээс хойш, түүнээс урагш, ээж аав, би, миний үр хүүхэд, өөрөөсөө илүүг сайн, дутууг муу гэхчлэн өөрийгөө оролцуулан ертөнцийг бүхэлд нь гурав ангилж ойлгодог.

Хүн өөрөө энэхүү гурван холбоост ертөнцийн зүй тогтолд, түүний төвд нь төрж, өсөж, өтлөх энэхэн зуур дараагийн үе, үр удмаа хөлийг нь дөрөөнд хүргээд амьдралын их хуулиар өвгөдийн араас энэ ертөнцийн мөнх бусыг үзүүлж, дараагийн үедээ байраа тавьж өгөөд, амьдралыг цааш тасралтгүй үргэлжлүүлэхэд хувиа нэмэрлэдэг. Гурвын холбоо хvmvvnий амьдралд их утга учрыг илэрхийлдэг нь үүнтэй холбоотой. Энэ санаа хэдийд хэнээс анхлан гарч, хэн хэрхэн хөгжүүлсэн болох нь өнөөдөр тодорхой биш боловч хэн хүнгүй энэ тоог эрхэмлэж, аливаа зан үйлийнхээ хэмжээг түүний хүрээнд тогтоож байдаг.

Энэ ертөнц, түүн дээрх амьдралын мөн чанарыг таньж мэдсэн үеэсээ эхлэн хүн түүнийг бэлгэдэх, янз бүрийн нөхцөлд төлөөлүүлэн хялбараар тэмдэглэх нь их эртнээс эхэлсэн байна. Энэхүү бэлгэдэл нь хөгжлийн жамаар боловсронгуй болсоор бидний үед ирсэн ба цаашид ч хөгжих жамтай аж. Энэ талаар хэл бичгийн шинжлэх ухааны доктор, профессор с.дулам «бэлгэдэл бол үнэн хэрэгтээ бид өөрсдөө ухамсарласан эсэхээс үл шалтгаалан өдөр тутмын ажил, амьдралдаа үргэлж тулгарч байдаг тийм үзэгдэл юм. Бэлгэдэл нь бидний дүрслэх бодлын зүрх судас болж, үл танигдах төгсгөлгүй бүхнийг нээн харах, тэр дундаа ухамсар бусын чанад хадгалагдсан эрдэнэсийн өвийг хөндөх зүг чиг хөтөлж байна»[4.3] гэсэн байна. Боловсролын тухай ойлголт гүнзгийрч, түүний одоогоор танин мэдэгдээгүй шинэ шинэ шинж чанаруудыг хүн нээн гаргахын хэрээр түүний бэлгэдэл, тэмдэглэл нь ч мөн цааш хөгжих нь гарцаагүй.

Танин мэдэхүй, түүний үр дүн болсон боловсролын үйл ажиллагааны эхний энгийн доод түвшин нь хүн хүрээлэн буй ертөнцийг таних анхдугаар шат юм. Танин мэдэхүйн тухай сонгодог онолыг боловсруулагчид ертөнцийн зүй тогтлыг танин мэдэх анхдагч үе шат нь хүний өөрийн эмпирик практик гэсэн байдаг. Шинэ хүнийг хүний нийгмийн орчинд оруулж, уламжлал, ёс заншилд сурган, орчин тойрныг таниулахаас хүний хүмүүнжил, түүний үйл явц болох боловсрол эхэлнэ. Амьдрал хүнийг танин мэдэхүйд хөтөлж, мэдэхгүйн харанхуйгаас түүнийг гэгээнд гаргах энэ шатыг бид бэлгэдэл гурвалжингийн суурь хэсэг дэх тод бараан өнгийн жижиг намхан гурвалжингаар дүрслэв. Энэ хэсэг нь боловсролын андагч суурь бөгөөд хүн орчны

тухай мэдээлэл хүлээн авч, мэдлэг бүрдүүлэх шат юм. Үүнийг философийн шинжлэх ухаан хүний тархин дахь бодит ертөнцийн субьектив тусгал хэмээн үздэг. Хүн орчноо таньж, би ба би бишийн ялгааг мэдсэний үр дүн нь мөн чанарыг ухааран ойлгох явдал ба боловсрох үйл явцын дараагийн шат болно. Энэ үед хүрээлэн буй орчлон ертөнц, юмс үзэгдлийн шалтгаан, үр дагаврын холбоо ба тэдгээрийн дотоод мөн чанар нь гадаад хэлбэрээрээ илэрдэг зүй тогтлыг ухаардаг. Хүний боловсролын шатыг эмблемийн дунд хэсгийг эзлэн, сууриасаа ялгаран харагдах цайвар гурвалжингаар дүрслэв. Боловсролын бэлгэдлийн энэ хоёр суурь гурвалжин нь сурган хүмүүжүүлэх ухааны үүднээс мэдлэг ба чадварын түвшнийг илтгэдэг.

Боловсрол судлаачид үе үеийнхнийхээ хөдөлмөрийг зарцуулсан судалгааны чиглэл бол боловсрол, түүний дотроос мэдлэг, чадвар, хандлагын харьцааны асуудал байв. Тэд мэдлэгийг хүн хэрхэн бүтээдэг, түүнийг хэрхэн эзэмшдэг тухай асуудалд өмнө нь их анхаарал тавьж ирж. Энэ сэдэв одоо ч боловсрол судлалын шинжлэх ухааны нэг голлох объект хэвээр байгаа ба мэдлэг ба чадварын диалектикийг тодруулан судлах нь бидний монголчуудын хувьд онцгой чухал ач холбогдолтой юм.

Хүн төрөлхтний бий болгосон мэдлэгийн их ертөнц та биднээс хараат бусаар, биднээс ангид бие даан оршдог. Мэдлэгийн тэр их сангаас үе үеийнхэн, тодорхой бие хүмүүс өөр өөрийн савны хэмжээгээр авч хүмүүнжин, хүмүүний үе удмыг тасралтгүй үргэлжлүүлэн одоог хүргээд, мөнхүү тэр мэдлэгийн ертөнцийг арвитган хөгжүүлсээр байна. Дурдан буй тэр их мэдлэгийн дотор түмэн хэл, далан өнгийн амьтан дэлхийн энд тэнд ийн тийн амьдрах ба тэдгээр нь тийм ч сайхан байгальтай, ийм ч сайхан амьдралтай гэлцэх нь ч мөн орно. Энэ бүгдийг сонсож, өөрийнхөө байгаатай харьцуулж бодсон, нүдээр харсан хэнд ч болов тэрхүү сайхны хүсэл хязгааргүй оргилох нь хүмүүний ёс юм. Энэ нь мэдлэг бөгөөд хэн нэгний мэдсэний хэмжээгээр тэр сайхан ертөнц өөрөө буй болох нь үгүй юм. Түүнийг мэдлэгтэй хүн бүр буй болгож чадахгүй. Үүний тулд чадвар хэрэгтэй болох ба тэрхүү ертөнцийн хязгаар дахь сайхан амьдралыг санаашран сууж мөрөөдөх биш, түүнийг гараараа байгуулан сүндэрлүүлэх хэрэгтэй юм.

Бидний цөөхөн монголчууд ертөнцийн сайн муу, сайхан муухайн тухай, дэлхий хавтгай юу, бөөрөнхий юу хэмээн ярих, хэлэлцэхэд үнэхээр чадварлаг бөгөөд эд баялгийг бүтээж, үйлдвэрлэхдээ харин гологдолтой байдаг. Энэ нь

бид мэдлэгтэй боловч хүссэн тэр сайхнаа өөрөө гараар бүтээх чадвар мөхөс гэсэн үг юм. 1912 хажуудах орос, хятадаас аваад холын америк англи, арлын япон, уулын непал, бутан хүртэл уулыг нурааж, усыг эргүүлж, хүн ардын амьдралын орчныг үзтэл өөрчлөн, сайн сайхнаар амьдарч байна. Ингэж эцэж, цуцалтгүй хөдөлмөрлөх дургүй, бүтээх чадваргүй бидний зарим хүмүүс хаа нэгтэйгээс уншиж, сонссон тэр хүсэл шуналдаа хөтлөгдөн, эд баялгийг мөрөөдөвч олдохгүй, өөрөө бүтээж чадахгүй тул түүнийг хүнээс булааж авах, ингэхийн тулд хүний амийг хөнөөх хүртэл адгуусан чанараа гаргаж, хожмын өдөр хүнд ялд унаж буйн цаад учир нь хүнд мэдлэг эзэмшүүлж, цаашлаад чадвар, хандлагыг шатлан төлөвшүүлээгүйтэй холбоотой. Хүсэл, мэдлэг хоёроор ертөнц сайхан болдоггүй. Түүнийг хүний гараар, бүтээлч хөдөлмөрөөр буй болгодог. Өмнөх түүхэнд гарч байсан дайн байлдаан, өнөөдрийн гудамжны дээрэм хоёрын үзэгдэх өнгө, цар хүрээ нь ялгаатай мэт боловч авах идэхийн шуналаар, өөрөө бүтээж чадаагүйг хүнээс булаан авч байгаа мөн чанараараа ижил юм. Иймээс боловсролын эцсийн зорилго нь хүн хэмээгч биологийн амьтныг бие хүн гэх нийгмийн гишүүн болгож, хөдөлмөрөөрөө хүний ертөнцийг буй болгоход бэлдэх явдал юм. Хүний хэрэглээ, хүсэл хязгааргүй, харин түүнийг буй болгогч чадвар, бололцоо хязгаарлагдмал нь боловсролын зорилгыг тодорхойлох аргазүйн үндэслэл болно.

Хэрэв хүний насан туршийн боловсролыг сүмбэр их уултай зүйрлэвэл тэртээ тэнгэрийн хаяанд алсаас цайран харагдах түүний өндөр цагаан оргил нь, энэ гурвалжингийн хувьд титэм хэсэг нь боловсролын гуравдугаар, гэгээрлийн шат юм. Хүн өөрөө байнга төгс төгөлдөрт тэмүүлж, түүнд шинэ шинэ хэрэгцээ байнга үүсэж байдаг үргэлжийн, цаглашгүй мөн чанартайгаас гэгээрэлд тэмүүлэн, бодь сэтгэлд хүрэх эрмэлзэл нь эртнээс улбаатай юм. «Оршин тогтнох хийгээд түр зуурын мэдрэхүйн хүслээ хангах төдий аз жаргалыг хайх амьтны төвшнийг даван туулж» [147], дотоод сэтгэлээ ариусган төгөлдөржүүлж, уужим сэтгэл, хүмүүнлэг нигүүлсэхүйн чанарыг ямагт өөртөө хөгжүүлэн, амьдрах чадвараа тасралтгүй нэмэгдүүлж, зовлонгийн чанадад гарах нь хүний гэгээрлийн зөв зам мөр юм.

Эрдмийн энэ сүмбэр цагаан уулыг бэлээс харсан гэнэн хүнд ойрхон мэт бодогдовч гэгээрэхүйн тэр сүрт цагаан оргилд хэн хүн нэгэн насанд гарахгүй гэх ба тэр их уулсын сүрт оргилд мацах өргөн дардан зам үгүй тул эрдмийг чуулж, гайхамшигийг

бүтээх тэрхүү бартаат зөргөөр биеийг үл хайрлах эрдэмт мэргэн хүмүүс мачийн зүтгэсээр насыг элээж, дараа дараагийн үедээ халаагаа өгсөөр авай. Өнөөдрийн та биднийг хүртэл энэ дэлхий дээр төрж, өсөж, бурхан болсон 200 тэрбум хүний мэдлэг, чадвар, эрдэм хуримтлагдан нэмэгдэхийн хэрээр тэрхүү сүмбэр цагаан оргил улам улам алслан холдож өндөрссөөр өнөө бидний энэ үед хүрч иржээ. Оюун санааны энэ их хуримтлал нь хөгжлийнхөө явцад саарыг гээж, сайныг батжуулсаар манай тооллын хоёр дахь мянганы эцэст глобалчлал хэмээх хүн төрөлхтний хөгжлийн шинэ шатыг буй болгов.

Хүн өвөг дээдсээсээ уламжилж аваад, түүхийнхээ явцад төгөлдөржүүлж хөгжүүлсээр авч ирсэн боловсрол хэмээх нийгмийн энэ үйл ажиллагааны дотоод мөн чанарыг боловсрол судлалын шинжлэх ухааны бэлгэдэл болгож бидний санал болгож байгаа бие биеийг дотроо багтаасан адил талт гурван гурвалжингаас тогтох энэ бэлгэдлийн дотоод агуулга нь хамгийн энгийн, товч байдлаар ийм юм.

Дүгнэлт Боловсрол, түүний мөн чанар, үйл ажиллагааг хялбар ойлгомжтой дүрс тэмдгээр бэлгэдэн харуулах оролдлого эртний уламжлалтай ба энэ бэлгэдэл нь цаг үеэ даган өөрчлөгдөн хувьсаж иржээ.

Одоо үед боловсролын тухай ойлголт өргөжин, утга агуулга нь гүнзгийрэхийн хэрээр дэлхийн олон оронд түүнийг улам ч олон янзаар бэлгэдэж тэмдэглэх болов. Энэ нийтлэг хандалга манайд ч тусгалаа олж байна.

Бидний санал болгож байгаа боловсролын бэлгэдэл нь бие биеийг дотроо багтаасан адил талт гурван гурвалжингаас тогтох хамгийн энгийн дүрс бөгөөд хувь хүн, нийгмийн хөгжилд боловсролын гүйцэтгэж байгаа үүрэг, ач холбогдлыг бүрэн дүүрэн, товч тодорхойлон харуулах боломжтой юм.

Номзүй

1. Дээрхийн гэгээн XIV далай лам, Шинэ Мянганы хүмүүн төрөлхтний ёс зүй. Уб, 2001, 47-р тал.
2. Дээрхийн гэгээн XIV далай лам, Амар Тайван амьдрахуйн зурлага. Уб, 2002, 112-р тал.
3. Бэгз Н, Глобальчлалын үеийн монгол улсын боловсролын хөгжлийн онол, аргазүйн үндсэн асуудлууд. Уб, 2001, 163-р тал.
4. Дулам С, Монгол бэлгэдэлзүй. Тэргүүн Дэвтэр. Тооны бэлгэдэл зүй. Уб, 1999, 5, 19-р тал.
5. Намжил Т, Монголчуудын гэр бүлийн хүмүүжлийн үүсэл. Боловсрол судлал. 2002, 1-31.